

Бэлгэх хуудас

Шинээр ажилтан авахаасаа өмнө



Хэрхэн зөв аргачлалаар зөв хүнээ зөв ажлын байранд шалгаруулж авах вэ? Энэ талаар зөвлөмжийг хүргэж байна.

Ажил 1: Анкет боловсруулах

- Шинээр авах ажлын байранд авах хүний мэдлэг үр чадвар, ерөнхий мэдээллийг бүрэн харах боломжтой анкетны газар боловсруулах.
- Анкетны хэсэгт тухайн хүний цаашдын амьдралын зорилго болон төлөвлөгөөний талаар бичих хэсэг оруулах. Иймэрхүү нэмэлт бичлэгүүдээс тухайн хүний хэрхэн өөрийгөө үнэлж, тодорхойлох чалдварын харах боломжтой.

Өргөдлийн маягт бөглүүлэх

- Бөглүүлэхийн өмнө уншуулах, тайлбарлах
- Гүйцэд бөглөхийг сануулах
- Анкетыг хүлээн авахдаа бүрэн бөглөсөн эсэхийг шалга

Өргөдлийн маягтыг судлах

- Анкетыг бөглөсөн байдал (бичгийн хэв, үг үсгийн алдаа, асуултанд зөв, бүрэн хариулсан эсэх)
- Ажлын туршлага нь танд байгаа ажлын байрны шаардлагыг хэр хангах вэ?
- Шаардлага ба анкетыг харьцуулах (цалин, нас, туршлага)
- Анкетыг судалсаны дараа боломжит цөөн ажил горилогчдыг сонгох

Ажилд авах ярилцлагын бэлтгэл

- Ярилцлагын хуваарь боловсруулсан байх/төлөвлөх
- Анкетын судалгааг хийсэн байх
- Ярилцлагаас юу мэдэж авахаа тодорхойл
- Ярилцлагад ашиглах маягтуудыг бэлтгэх
- Ярилцлага явуулах аргаа сонгох

Ажилд авах ярилцлага явуулах

- Танилцуулга (найрсагаар угтах, гар барих) Өөрийгөө танилцуулахыг хүсэх
- Анкетын мэдээллээс асуух (таны судалгаа дүгнэлттэй хэрхэн тохирч байна вэ?)
- Ажлын талаар танилцуул (ажлын гол үүрэг, ажил олгогч, ажлын орчин)
- Нэр дэвшигчид өөрийгөө үнэлэх боломж олгох (Таны чадвар уг ажлыг гүйцэтгэхэд хэрхэн зохицох вэ? нээлттэй асуу,Та энэ ажлыг хийж чадах уу? гэж асуухгүй)
- Хаах (эргэж холбоо барихаа амал, ирсэнд нь талархах)

Мэдлэг шалгах үндсэн асуулт(тест)

- Шаардлага хангаж болох цөөн хүмүүсийг шалгалтанд оруулна.
- Ажлын байран дээр тодорхой ажил үүрэг өгч гүйцэтгүүлэх
- Ажилтай холбоотой зарим асуултуудыг асууж, хариултыг бичгээр авах
- Хувийн сонирхол, зан байдлын талаар асуулт бичгээр асуух.

Жишээ нь: Тантай хамт ажилладаг сайн найз тань илүүдэл материалыг гэр лүүгээ авч явдгийг та мэдвэл яах вэ? Таны хамтран ажиллагч бага хэмжээний гологдол бүтээгдэхүүн гаргажээ.Түүнийг нь та мэднэ. Найз тань даргад бүү хэлээч гэж гуйжээ. Та яах вэ?

Судалгаа шинжилгээ, боловсруулалт хийх

- Нэр дэвшигч бүрийн чадвар, туршлагыг харьцуулах
- Асуултуудын урьдчилан бэлтгэсэн боломжит хариултуудтай харьцуулах
- Нэр дэвшигчийн талаар лавлагаа авах – Боловсролын талаар, ажлын туршлага, гэмт хэрэгт холбогдсон байдал, хувийн зан чанарын талаар
- Ажил горилогчийн хариулсан хариултуудыг шалгах

Шийдвэр гаргахдаа анхаар

- Ажлын шаардлага хангах эсэх
- Ажил хийх сонирхол
- Цаашид хөгжих, сурах боломж

- Ажлын нөхцөл, орчинд зохицох чадвар
- Сэтгэл зүйн онцлогийг ч бас харгалзан үзнэ.